



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7 дахь хэсэг, Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 115 дугаар тогтоолоор батлагдсан “Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчим хүчний сайдын 2021 оны төсвийн хөрөнгө оруулалтын багцад тусгагдсан төсөл, арга хэмжээнүүдийн Захиалагчаас гаргасан зөвлөмжийг үндэслэн гэрээ байгуулах хэлэлцээр хийх байнгын үйл ажиллагаатай ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд

Ажлын хэсгийн дарга:

-Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга

Ажлын хэсгийн гишүүд:

-Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга

-Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын /Дулаан, Цахилгааны/ хэлтсийн ахлах шинжээч

-Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн хяналт хариуцсан ахлах шинжээч

-Эрчим хүчний хөгжлийн төвийн Ерөнхий инженер

-Эрчим хүчний хөгжлийн төвийн Захиалагч, хяналтын хэлтсийн дарга

Ажлын хэсгийн гишүүн бөгөөд нарийн бичгийн дарга:

-Эрчим хүчний хөгжлийн төвийн тухайн төсөл, арга хэмжээ хариуцсан хяналтын инженер

170600101

2.Эрчим хүчний салбарт 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж эхлэх төсөл, арга хэмжээний Захиалагчаас гаргасан зөвлөмжийг үндэслэн тендерийн хүчинтэй байх хугацаанд захиалагч, гүйцэтгэгчийн хооронд гэрээ байгуулах хэлэлцээр хийж, хяналт тавин ажиллахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



Б.НАСАНТОГТОХ

